

## СЭТГҮҮЛЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Д.Сандагсүрэн\*

\*Сити Их Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D)

**Түлхүүр үгс:** хэвлэлийн цензур, мэргэжлийн ёс зүй, сэтгүүлчийн хараат бус байдал, сэтгүүл зүйн үүрэг, мэргэжлийн хэм хэмжээ

**С**этгүүлчийн бие даасан, хараат бус байдал нь сэтгүүлч өөрийн нийтэлж, нэвтрүүлэх мэдээллийн агуулгыг бие даан сонгох эрх гэж үздэг. Энэ эрх нь олон түмний “мэдэх эрхэд шударгаар үйлчлэх” гэдэг ганц л зарчмаас үүдэлтэй. Тэгэхээр сэтгүүлч хараат бусаар ажиллахад зөвхөн хэвлэлийн чөлөөт байдлаас гадна сэтгүүлчийн бие даан шийдвэр гаргах эрх чухал байх нь. Тиймээс бид энэ өгүүлэлд сэтгүүлчийн бие даан, хараат бусаар ажиллах нөхцөл боломж манайд ямар байгааг тандах, сэтгүүлчийн чөлөөтэй ажиллахад саад болж буй ямар асуудал байгааг хөндөхийг зорилоо.

**Иргэдийн мэдэх эрхэд үйлчлэх сэтгүүлчийн үүрэг.** Бид сэтгүүлчийн хараат бус байдлын тухай ярихдаа ихэвчлэн хэвлэлийн хараат бус байдлын тухай ярьж ирсэн. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдал нь сэтгүүлчийн бие даасан, хараат бусаар ажиллах гол суурь нөхцөл мөн. Гэхдээ чөлөөт хэвлэл бүрдсэнээр сэтгүүлчийн

хараат бус байдал хангагдахгүй гэдэг нь өнөөгийн сэтгүүл зүйн практикаас ил байна. Тэгэхээр сэтгүүлчийн хараат бус байдал гэдгийг хэвлэлийн чөлөөт байдал гэдгээс илүү өргөн хүрээнд авч үзэх хэрэгтэй болжээ.

Сэтгүүлчийн хараат бус байдал нь юугаар илэрхийлэгдэх вэ? Юуны өмнө нийтэлж, нэвтрүүлж байгаа мэдээлэл нь тухайн редакцын үзэл бодол, хэвлэл, мэдээллийн хэрэгслийг эзэмшиж байгаа, эрхэлж байгаа эзэн болон эрхлэгч, ерөнхий редакторуудын үзэл бодолтой нийцэхгүй байсан ч мэргэжлийнхээ зарчмаар сэтгүүлч өөрийн эрх мэдлээр зохицуулах харилцаа гэж ойлгож болно. Сэтгүүлчийн энэхүү эрхийг эрх зүйн зохицуулалтаар хангаж өгөх нь сэтгүүлч бодит байдлыг хэн нэгэн эрх мэдэлтний өнгө үзэмж, үзэл бодлоос ангид байдлаар нийтэд хүргэхэд чухал ач холбогдолтой.

Тэгэхээр сэтгүүлч өөрийн ажиллаж буй хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгч хэн байхаас үл хамааран үйл ажиллагаагаа сэтгүүлчийн ёс зүйд нийцүүлэн хараат бусаар явуулах үүрэгтэй ажээ. Энэ нь дээр дурдсанчлан сэтгүүлчийн эрх гэхээсээ бусдын мэдэх, бодит мэдээлэл авах эрхийг хангах чиг үүрэгтэй нь холбоо-

той. Тэгэхээр аль ч хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж буй сэтгүүлч нийтлэлийнхээ сэдэв, агуулгыг хэний ч заавар, нөлөө нөлөөллөөс ангид сонгон бичиж нийтлэх ёстой болж байна. Гэтэл практик дээр сэтгүүлчийн юу бичих, яаж бичихийг эрхлэгч нар өдөр бүр зааварлах, үүрэгдэх төдийгүй, сэтгүүлчийн бичсэн материалыг өөрөө ч танихгүй болтол нь засаад нийтлэх нь байдаг л үзэгдэл.

Сэтгүүл зүйн нийтлэлийн бодлогын нэгдмэл байх зарчмын үүднээс авч үзвэл хариуцлагатай этгээд нь сэтгүүлчдийн үйл ажиллагааг зангидаж, мэргэжлийнхээ зарчмаар хяналт тавихыг үгүйсгэхгүй. Учир нь сонин хэвлэлд буруу зөрүү, магадалж нягтлаагүй мэдээлэл тавих, санаатай, санамсаргүй байдлаар хэн нэгний нэр хүндийг гутаах, баримтаар баталгаажих нотлогдоогүй, сураг ажиг бүхий, эсвэл огт худал ташаа мэдээлэл гардаг. Энэ асуудлаар шүүхэд хэн нэгэн гомдол гаргахад сэтгүүлч ч биш, эзэн ч биш, эрхлэгч дуудагдаж очдог, мэдээллийг хянаж гаргаагүй гэдгээрээ эрхлэгч хуулийн хариуцлага хүлээдэг. Тиймээс хэвлэлийн эрхлэгч, редакторууд сэтгүүлчийн нийтлэл, нэвтрүүлгийг хянах, зарим үед засварлахаас өөр аргагүй байдаг. Мэргэжлийн шаардлага талаасаа энэ бол цензур биш. Гэхдээ энэ бол эрхлэгч нарыг сэтгүүлчийн хараат бус байдал руу “халдахад” хүргэх ёсгүй. Энэ зааг ялгааг манай эрхлэгч нар мэддэг. Гэхдээ заримдаа ойшоохгүй, ач холбогдол өгөхгүй байгаа нь ажиглагддаг.

Хуульч М.Батсуурь “Редакцын хараат бус байдал: Эрх зүйн зохицуулалт ба харьцуулалт” судалгаандаа хэвлэл мэдээлэлд төрөөс тавьдаг тодорхой хориглолт байдаг

талаар өгүүлсэн байна. “Ардчилсан олон оронд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд төрөөс тавих хяналтыг хуулиар хориглосон байдаг ч тухайн мэдээллийн агуулга, зорилгыг харгалзан тодорхой хязгаарлалтыг хийдэг байна. Үүнд:

- *Ёс суртахууны хязгаарлалт* буюу олон нийт, иргэдэд хүргэхэд ёс зүйн хувьд тохиромжгүй мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтрүүлэхийг хориглодог.
- *Батлан хамгаалахын хязгаарлалт* буюу улс орны батлан хамгаалах, цэрэг зэвсгийн хүчин чадалтай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, түгээхийг улсын аюулгүй байдлын үүднээс хориглодог.
- *Улс төрийн хязгаарлалт* буюу ард иргэдийн дунд үймээн самуун дэгдээх, улс төрийн тогтворгүй байдал бий болгох аливаа сөрөг ташаа мэдээллийг нийтэд хүргэхийг хориглодог.
- *Шашны хязгаарлалт* буюу тухайн оронд зэрэгцэн оршиж буй шашны тэнцвэрт байдлыг хадгалах үүднээс хэт нэг талыг барьсан, бусад шашны холбогдолтой сөрөг мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхийг хориглодог.

**Э**дгээр хязгаараас давсан хязгаарлалт хийсэн тохиолдолд улс төрийн хараат байдал тодорхой хэмжээнд бий болсон гэж дүгнэдэг” (Батсуурь, 2010) хэмээн бичсэн байна.

Өөрөөр хэлбэл, сонины эрхлэгч, телевиз, радиогийн захирлууд дээрхээс бусад асуудлаар сэтгүүлчийн бичсэн зүйлийг цензурдэх нь сэтгүүлчийн бие даасан, хараат бус байдалд халдсан хэрэг болох нь. Харин үүгээр “далимдуулан” эрхлэгч

нар өөрт таалагдаагүй үг, өгүүлбэр бүрийг шүүрдэж сууж таарахгүй гэдэг нь ойлгомжтой байна.

Судлаач А.Оюунгэрэл “Хэвлэлийн магнатууд хувийнхаа сонирхлыг редакцын бодлогод тусгах хүсэлтэй байдгийг судлаачид /Tunstal & Palmar, 1991/ тогтоожээ. Тиймээс либерал онол /Liberal theory/-оор хэвлэл мэдээллийн эзэд нь агуулгын шийдэл хийх үйл ажиллагаанаас тусгаарлагдсан байх ёстой гэж үздэг. Эзэд эсвэл төлөөлөн удирдах зөвлөл нь нөөц ашиглалт, бизнесийн стратегийн талаар шийдвэрийг гаргадаг. Харин эрхлэгч агуулгын талаар мэргэжлийн шийдвэр гаргаж байх ёстой гэж энэ онол тайлбарладаг” (А.Оюунгэрэл, 2009) гэсэн байх юм. Энд эзэн, эрхлэгчийн үүргийг яв цав тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, эзэнд бизнесийн эцсийн үр дүн, хэтийн зорилт хамаатай бол эрхлэгч зөвхөн мэргэжлийн буюу агуулгын шийдвэр л гаргах эрхтэй гэж тэдний ажлын онцлогийг зааглаж өгсөн байна. Харин сэтгүүлчид, редакцын хамт олон эзэн, эрхлэгчийн дарамт дор биш, мэргэжлийн хэм хэмжээнд захирагдан ажиллах учиртай.

**Х**эвлэл, мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, хувь эзэмшигч редакцын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, тэрчлэн ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч тухайн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад нөлөөлөхийг хориглосон тохиолдолд л сэтгүүлчийн хараат бус байдлыг хангах боломжтой болно. Гэтэл манайд энэ талын харилцааг зохицуулсан эрх зүйн акт тун хомс байна.

**Бусдын нөлөөнд сайн дураар орох нь.** Манай улс төр, бизнесийнхэн сэтгүүлчдийг элдэв

урамшууллаар урхиддаг нь нууц биш юм. Сэтгүүлчид оройн хоол, үнэгүй амралт, зугаалга, гадаад дотоодод аялах зэргээр мөнгөтэй хүмүүсийн халаасанд өөрсдөө сайн дураараа ордог. Сэтгүүлчдийн цалин хөлс бага, ажлын цаг урт, илүү цагийн мөнгө өгдөггүй зэргээс болж дээрх маягаар худалдагдахад хүрдэг.

Мөн сэтгүүлчдийн улс төр, бизнесийн зарим нэгнийг үгээр “долоох”, хуурай магтах, тал зассан өнгө аястай нийтлэлүүд сонин хэвлэл, социал медиагаар дүүрэн байгааг анзаарахгүй байхын аргагүй. Хамгийн сүүлийн үеийн жишээ гэхэд л сэтгүүлч Ш.Даваадоржийн “нүүрсний хэрэгт” татагдаад байгаа УИХ-ын гишүүн, “Ажнай” Б.Бат-Эрдэнийг “өмөөрсөн” нийтлэл байна. “Нүүрсний хулгайн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа төрийн өндөр албан тушаалтныг гэмт хэрэгт холбогдуулан шалгаж эхэлж буй үед тэр хүний талаар цулгуй магтаалыг сошиалаар урсгаж, түүний өмнөөс “матрын нулимс унагаж суух” нь сэтгүүлчийн ёс зүйд үл нийцнэ.

Сэтгүүлчдийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллын талаар ажил олгогчтой хэлэлцээр хийх зэргээр тэдний эрх ашгийг хамгаалдаг хүчтэй үйлдвэрчний эвлэл ч байхгүй байна. Сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллага ч энэ талаар дорвитой ажил хийхгүй байна. Үүнээс үүдэн олон сэтгүүлч төлбөрт нийтлэлээс шан харамж хүртдэг, далд сурталчилгаа бүхий мэдээ бэлтгэн нийтэлж нэвтрүүлэн далдуур мөнгө санхүүгээр угжуулдаг зэрэг аюултай балчигт шигдэхэд хүргэж байна. Үүнээс үүдэн сэтгүүлч төдийгүй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь өөрөө эргээд мөнгөтэй байгууллага, хүмүүсээс хараат болж байна.

Энэ мэтээр сэтгүүлчид эзэмшсэн мэргэжлээсээ “урваж”, сэтгүүлчийн ёс зүйгээ уландaa гишгэж, өнгө мөнгөөр худалдагдах, авлигад өртөж буй нь иргэдийн үнэнийг мэдэх эрхэд ноцтой хохирол учруулж байна.

Судлаачийн дүгнэснээр “Зарим оронд редакцын бодлого, сэтгүүлчдийн эрх чөлөөг хамгаалахаар редакцын журам гаргаж мөрддөг.

Тийм журам байхгүй нөхцөлд хэвлэл мэдээлэл ямагт олон нийтийн хяналтад байдаг болохоор эздийн нөлөөллийг үгүйсгэхийн тулд сэтгүүлчид нь мэргэжлийн байдлаа хадгалж, ёс зүйгээ сахиж, нэр хүндээ өндөр байлгах хэрэгтэй болдог”

(А.Оюунгэрэл, Олон түмний харилцааны онол, 2009) байна. Гэтэл манайд редакцын иймэрхүү журам боловсруулж мөрдүүлсэн практик алга. Сэтгүүлчид улс төрчид болон бизнесийн эздийн мөнгөөр гадаадад зугаалах, аяллаар явах, амралтад амрах зэрэг нь сэтгүүлчдийн хувьд түгээмэл үзэгдэл болсон. УИХ-ын ээлжит сонгуулийн дараа иймэрхүү арга хэмжээ хэрээс хэтэрдэг.

Энэ нь сэтгүүлчид томоохон компани, бизнесмен, улс төрчдийн нөлөөнд орох, сэтгүүлчдийн хараат бусаар ажиллахад ихээхэн саад болж байна. Тиймээс сэтгүүлчид бизнес

эрхлэгчид, улс төрчдийн оройн зоог, гарын бэлэг, өчүүхэн урамшуулал зэргээс татгалзаж сурах ёс зүйг редакцын дүрэм журмаар мөрдүүлж төлөвшүүлэх нь чухал болжээ. Сэтгүүлчид цалин багатай, нийгмийн халамж хангамж сул гэдгээр гул барьж дээрх ёс зүйгүй үйлдлийг зөвтгөх ямар ч аргагүй.

### **Сэтгүүлчийн өөрийн цензур.**

Хэвлэл мэдээллийн салбарт байдаг өөр нэг түгээмэл үзэгдэл бол сэтгүүлчийн өөрийн цензур юм. Социализмын үед нийгмийн тогтолцоог шүүмжилж болдоггүй байсан. Сэтгүүлч, хэвлэлийн эрхлэгч нар улс төрийн алдаатай утга агуулга бүхий мэдээ материал сонин хэвлэлдээ гаргаж “хэрэгт орохоос” айдаг, адаглаад л ГАЛАВ-ЛИТ-ийн хараа хяналтад орохоос болгоомжилдог байв.

Харин одоо бол сэтгүүлчийн “айдаг” зүйл өөр болжээ. Харилцагч байгууллагатай зөрчилд орж болзошгүй тул тэднийг шүүм-

жилж болохгүй. Наад зах нь рекламн гэрээгээ цуцалбал сонинд хохиролтой болно. Аягүй бол эзэн утасдаад дарамтална. Түүнд муугаар харагдаад дэмий. Нутгийн “ах”-ыг муу хэлж болохгүй. Их мөнгөтэй хүнийг оролдвол хэрэгт орно. Улс төрчдөөс хол явъя. Бизнесменүүдээс зай барьж



**Сэтгүүлчид улс төрчид болон бизнесийн эздийн мөнгөөр гадаадад зугаалах, аяллаар явах, амралтад амрах зэрэг нь сэтгүүлчдийн хувьд түгээмэл үзэгдэл болсон. УИХ-ын ээлжит сонгуулийн дараа иймэрхүү арга хэмжээ хэрээс хэтэрдэг.**

**Энэ нь сэтгүүлчид томоохон компани, бизнесмен, улс төрчдийн нөлөөнд орох, сэтгүүлчдийн хараат бусаар ажиллахад ихээхэн саад болж байна. Тиймээс сэтгүүлчид бизнес эрхлэгчид, улс төрчдийн оройн зоог, гарын бэлэг, өчүүхэн урамшуулал зэргээс татгалзаж сурах ёс зүйг редакцын дүрэм журмаар мөрдүүлж төлөвшүүлэх нь чухал болжээ**



явбал аминд өлзийтэй. Бас эрх мэдэл бүхий хүмүүсээс болгоомжлох ёстой. Үүсгэн байгуулагч, тэдний найз нөхдийн талаар муу юм бичиж болохгүй. Буруу хүнээ шүүмжилж “бодлогын алдаа” гаргахаас болгоомжлох ёстой. Энэ мэтээр сэтгүүлч эмээдэг, болгоомжилдог. Энэ бүгд бол сэтгүүлчийн өөрийн цензур юм.

Сэтгүүлчид улс төрчидтэй хэт их сүжрэх, найзлах нь эргээд тэр хүнийг бичих, шүүмжлэх “нүүргүй” болгодог. Таньдаг, чиний найзулстөрч муу үйлд хутгалдлаа гэхэд бичих хэцүү, бичихгүй байх бүр хэцүү. “Ширэн нүүрлээд” бичлээ гэхэд нэг өдөр түүнтэй уулзаж л таарна. Тэр үед эвгүй байдалд орж мэднэ гэх мэтээр сэтгүүлч өөртөө цензур тогтоох нь эргээд сэтгүүлчийн бичих туурвих эрхээ өөрөө хязгаарлах нэг шалтгаан болдог. Энэ мэтээр сэтгүүлчийн өөртөө тавьдаг цензур улам бүр ихсэх хандлагатай болжээ. Сэтгүүлч ийм байдлаар өөртөө цензур хаалт тогтоосноос болж нийгмийн эрх ашгийг хохироосон хууль бус зүйлийг ч тойрч гарах, өдөр тутмын аахар шаахар зүйлээр сонины хуудсаа дүүргэх болдог. Энэ нь эргээд иргэдийн мэдэх эрхэд ихээхэн хохирол учруулдаг.

Дээр өгүүлсэн бүгдээс дүгнэж үзэхэд сэтгүүлчийн хараат бус байдал зөвхөн бусдаас биш, сэтгүүлчээс, өөрөөс нь бас шалтгаалж болохыг харуулж байна.

Одоо сэтгүүлчийн хараат бус байдлын сөрөг ба эерэг талуудын талаар өгүүлье.

**Сэтгүүлчийн хараат бус байдал бол хэмжээгүй эрх чөлөө биш.** Сэтгүүлчийн бие даасан, хараат бус байдал бол бичих эрх, эрх чөлөө юм. Энэ бол сэтгүүлчийн хувьд том

боломж. Энэ эрх чөлөөг зөв “эдлэх” ёстой. Гэвч зарим сэтгүүлч бичих эрх чөлөө гэдгийг юуг ч, яаж ч бичиж болно гэж өрөөсгөл байдлаар ойлгох нь түгээмэл байна.

Сэтгүүлч хараат бусаар ажиллах нь сэтгүүлч ур чадвар, авьяас билгээ шавхан дайчилж урлан бүтээх гол нөхцөл юм. Харин энэ эрх чөлөөг юу ч бичиж болох хэмжээгүй эрх чөлөө гэж ойлгосон үед сэтгүүлчийн үзэг аюултай зэвсэг болон хувирдаг.

**С**үүлийн жилүүдэд сэтгүүл зүйн салбарт ажиглагдаж байгаа сөрөг хандлага нь сэтгүүлчийн хараат бусаар ажиллах эрхийг “хэтрүүлэхтэй” холбоотой янз бүрийн сөрөг үзэгдлээр илэрч байгаа. Тухайлбал, сэтгүүлч нийтлэлийг хэн нэгний захиалгаар бичих, бэлтгэх, далд сурталчилгаа хийх, хувийн ашиг сонирхлын үүднээс бичих, мэдээллийг шударга бус аргаар олж авах, заримдаа санаанаас зохиож бичих гээд мэргэжлийн сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдлүүд олноор гарах боллоо. Тэрчлэн сэтгүүлч өөрийн ажиллаж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчийн мэргэжлээ ашиглан бусдыг дарамтлах, сүрдүүлэх, ашиг олох хэрэгсэл болгох зэрэг хандлага нэлээд өргөн дэлгэрсэн байна. Энэ нь сэтгүүл зүйн үнэн, бодитой, хүнлэг байх, мэдээллийн тэнцвэрт байдлыг хадгалах, хүртээмжтэй байх зэрэг үндсэн зарчмыг уландаа гишгэж байгаа хэрэг. Энэ бол сэтгүүлчийн нэр хүндийг унагах, олон нийтийн итгэлийг алдах, мэдээллийн тэнцвэрт байдал алдагдах, хүлээн авагчдад сэтгүүл зүйн талаар буруу зөрүү ойлголт өгөх муу үр дагавартай. Нөгөө талаар сэтгүүлч хүн чанараа алдаж, хатуухан хэлбэл, “биеэ үнэлэгч”, “хөлсний бичээч”

болон хувирч, нийгмийн ямар нэг хурц асуудлыг билгийн нүдээр харж уудлан илчлэх биш, ийм мэдээллийг “мөнгө” гэж харахад хүргэж байна. Мөнгө өгвөл юуг ч, яаж ч бичихэд бэлэн сэтгүүлч олширвол аюултай.

Шан харамж, төлбөр авч нийтлэл бичих, хэн нэгнийг захиалгаар намнах, өс хонзонгийн сэдлээр хэн нэгнийг харлуулах, мөнгөтэй хүмүүсийг ангуучлах, алдаан дээр нь дөрөөлж шантаажлан мөнгө салгах гээд сэтгүүлчийн хувьд байж боломгүй ёс зүйгүй үйлдлүүд нь хараат бус сэтгүүл зүй биш юм. Саяхан арилжааны нэг телевиз студидээ урьж ярилцлага хийсэн хүнээсээ мөнгө төлөхийг шаардсан баримт бол нэг л жишээ. Мөн хэсэг сэтгүүлч нэгэн бизнесмений ёс зүйгүй үйлдлийн бичлэгийг олоод өөрсдийн ажилладаг сайт, сонин, телевиз, радиогийн нэр барин ээлж дараалан утсаар дарамталж, асар их хэмжээний мөнгө нэхсэн үйл явдлын талаар шуугьж байв.

**М**анай нэртэй сайтуудын нэг “Зариг.мн”-ийн эрхлэгч Н.Өнөрцэцэг “Монполимет” хэмээх уул уурхайн компанийн захирал Ц.Гарамжавын Монгол банкаар даатгал нөхөн төлүүлсэн их мөнгөтэй холбоотой баримтыг олж, түүнийгээ ашиглан уг компанийг байнга “гүвж”, дарамталж байгаа жишээ бий.

“Одоо та нар ЗАРИГ-ийг дийлээхээсээ нэгэнт өнгөрсөн. Үзэлт уншилт, санхүүжилт тогтчихсон. Ц.Гарамжавын өрийг төлж дуусгахыг харж байж санаа амарна, зогсохгүй!!! Бусад дарга нар ч хараад аваг, хэвлэл нэг зуухаараа тавьдаггүйг!!!”. Энэ бол “Зариг”-ын Өнөрөөгийн фейсбүүкт тавьсан мэдэгдэл. Хэвлэл бол “зуудаг” биш, мэдээлдэг, шүүмжилдэг, илчилдэг хэрэгсэл.

Харин дээрх үйл явдлыг удаан хугацаанд ажиглахад “Ноцтой баримтыг ашиглан тэр бизнесменээс мөнгө нэхээд тэр нь өгсөнгүй дээ” гэж хардахад хүргэж байна. Иймэрхүү шантаажийн, захиалгын сэтгүүл зүй газар авч байгаа нь сэтгүүлч хараат бусаар ажиллах эрхээ “хэтрүүлэн ашиглаж байгаа” үйлдэл юм.

Сэтгүүлчийн ийм бусармаг үйлдлийг редакцын ёс зүйн дүрмээр зохицуулдаг олон улсын практик бий. “Вашингтон пост” сонины редакцад зочны ширээн дээр хэн хүнгүй үзэж танилцаж болдог нэгэн зузаан ном байдаг. Тус сонинд ажиллахаар сонирхож байгаа хүн энэ номыг бүрэн судалж үзээд зөвшөөрсөн тохиолдолд ажилд орох эрх авдаг. Энэ номд тус сонины сэтгүүлчийн ажиллах нөхцөл, баримтлах ёс зүйн дүрмийг маш нарийн зааж өгсөн байдаг. Тэнд спортын сэтгүүлч зохион байгуулагчийн мөнгөөр билет авахгүй, өөрийн мөнгөөр авсан билетийн суудалд суухаас эхлээд сэтгүүлч шан харамж авах, оройн зоог, хоол унданд уригдах гээд бүх харилцааг зохицуулсан байдаг. Энэ нь сэтгүүлч хэний ч нөлөөнд авталгүй ажиллах боломжийг олгохоос гадна сэтгүүлч гагцхүү мэргэжлийн ёс зүйд захирагдах өндөр хариуцлагыг ойлгуулдаг байна.

Доктор (Ph.D) Ж.Батбаатар “Сэтгүүл зүйн үйл ажиллагааны хэм хэмжээ буюу юу болох, болохгүйн зааг хязгаарыг тодотгож өгдөг ёс зүйн дүрэм, түүний мөрдөлт, хэрэгжилтэд мэргэжлийн хяналт тавьдаг өөрийн зохицуулалтын системийг бүрдүүлэх” нь юу юунаас чухал болохыг онцлон дурдсан байна. Манай улсад Хэвлэл мэдээллийн зөвлөлийг байгуулан ажиллуулж буй жишээ бий. Гэхдээ энэ зөвлөл нь хүчтэй, нөлөөтэй ажиллах

шаардлагатай. Хэвлэл мэдээллийн зөвлөл сэтгүүлчдийнхээ алдаа оноо, ёс зүй, оюуны өмч, хэвлэлийн мэдээллийн чанар, хэм хэмжээг өндөр хэмжээнд хянаж явах шаардлага улам бүр өсөж байгааг хэлэх хэрэгтэй.

Сэтгүүлчийн хараат бус байдалд нөлөөлдөг дээрхээс өөр бусад олон хүчин зүйл байдгийг судлаачид олж тогтоосон байдаг. Сэтгүүлчийн мэдээлэл хайх, түгээх эрх, сэтгүүлчийн эрэн сурвалжлах үйл ажиллагааны хамгаалалт, төрийн байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах эрх, эх сурвалжаа нууцлах эрхийн хамгаалалт, сэтгүүлчийн үзэл бодолд нөлөөлсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо зэрэг бүлэг асуудлууд үүнд багтаж байна. Сэтгүүлчийн мэдээлэл хайх, түгээх эрхийг бид Үндсэн хуулиараа тунхагласан. Харин эрэн сурвалжлах үйл ажиллагааны үеийн хамгаалалт, албан тушаалтнаас мэдээлэл авах, эх сурвалжийг нууцлах сэтгүүлчийн эрхийг хуульчилсан зүйл өнөөдөр алга.

**С**этгүүлч хараат бус чөлөөтэй ажиллах, мэдээлэл авах, түгээх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад болж буй гол зүйл бол нууц эх сурвалжаа хамгаалахыг эрх зүйн хувьд баталгаажуулаагүй явдал юм. Монголын сэтгүүлчдийн эвлэлээс 2012 онд шинэчлэн баталсан “Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм”-д сэтгүүлч нууц эх сурвалжаа хамгаалах тухай заалт бий боловч энэхүү зарчим нь эрх зүйн ямар ч чадамжгүй юм. Шүүхийн практикт эх сурвалжаа илчлэх нь өөрийгөө хамгаалах арга хэмээн шахалт үзүүлэх, сэтгүүлчид ч эх сурвалжаа илчилж өөрийгөө аврах ёстой гэдэг ойлголттой байдаг. Шүүх, цагдаа сэтгүүлчийг эх сурвалжаа

илчлэхийг шаардаж дарамталдаг байдлаас болж сэтгүүлчид эрх мэдэлтнүүдтэй холбоотой зөрчилтэй мэдээллийг түгээхээс болгоомжилдог. Гүтгэлгийн эсрэг хэрэг үүсгүүлсэн хүмүүс өөрийгөө хамгаалахын тулд эх сурвалжийг илчлүүлэх гэж шүүхэд ханддаг явдал бий. Зарим тохиолдолд төрийн өндөр албан тушаалтнууд, бизнесийнхэн сэтгүүлчээр эх сурвалжийг нь хэлүүлэхийн тулд заналхийлэх явдал ч гардаг байна. Нийгэмд буй аливаа зөрчил доголдлыг илрүүлж нийтэд мэдээлэхэд нэрээ нууцлахыг хүссэн эх сурвалжууд чухал үүрэгтэй. Тэгэхээр мэдээллийн эх сурвалжийг хамгаалах асуудал сэтгүүлчийн хараат бус байдалд онцгой нөлөөтэй гэдэг нь ойлгомжтой юм.

Харин Хууль зүйн сайд Б.Энхбаяр “сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрх”-ийг хуульчлах талаар телевизээр мэдээлсэн. Гэхдээ хуульд ийм энэ заалт оруулж, эцэслэн батлагдах, эсэх нь одоогоор тодорхойгүй байна.

Дэлхийн 100 гаруй оронд мэдээллийн эх сурвалжийг хамгаалах хууль байдаг гэсэн статистик мэдээ бий. Эдгээр орны хуулиудад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээх мэдээллийн зохиогч өөрийн нэрийг нууцлах, нууц нэр хэрэглэх, мэдээлэл өгсөн этгээд өөрийгөө нууцлах эрхтэй гэж заасан байдаг. Мөн хуульд хэвлэл, мэдээллийн редакц, сэтгүүлч, нийтлэл, нэвтрүүлгийн зохиогчоос мэдээллийн эх сурвалжаа илчлэх, мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзсантай холбогдуулан аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлэх, хариуцлага хүлээлгэхийг хориглосон байдаг байна. АНУ-ын 33 муж улсын хуульд ийм заалт байдаг. Тэгэхээр Монгол

Улсад ийм хууль маш чухал байгаа юм.

Улсын болон байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг төрийн албан хаагч заавал гаргаж өгөхийг үүрэгжүүлсэн хууль ардчилсан ихэнх оронд байдаг. Гэтэл манайд ийм хууль байхгүйгээс хэн нэгэн төрийн албан хаагч өөрт хамаарах асуудлаар мэдээлэл өгөхгүй байхад сэтгүүлч яаж ч чадахгүй мухарддаг. Гэтэл АНУ-д өөрийн албан тушаалд хамаарах асуудлаар мэдээлэл өгөхөөс татгалзсан албан хаагчийг шүүхэд өгөхөд л хариуцлага хүлээж, мэдээллийг өгөхөөс өөр аргагүй болдог.

Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн хөгжлийг хазаарлаж буй Монголын хууль эрх зүйн өөр нэг баримт бичиг бол нэр, нэр төрийг гутаах, гүтгэлгийн талаарх хууль тогтоомж юм. Иргэний нэр, нэр төр, хувийн нууцыг манайд Эрүүгийн болон Иргэний хуулиар хамгаалж, энэ төрлийн хэргийг шүүхээр шийдвэрлэдэг. Энэ нь сэтгүүлчийн өөрийн цензурт ташуур өгдөг гэхэд болно.

**Сэтгүүлчийн хараат бус байдлаас сэтгүүлчийн бүтээлч сэтгэхүй шалтгаалах нь.** Сонин хэвлэлд юу нийтлэх нь цаг үеийн шаардлага, уншигчийн эрэлт хэрэгцээ, хүчтэй нийтлэлийн бодлоготой холбоотой боловч, сэтгүүлчийн санал санаачилга, хүсэл зориг, тэмүүлэл дээрхээс дутуугүй чухал байдаг билээ. Ямар сэдвийг хөндөх, ямар асуудалд анхаарлаа хандуулах нь нэг талаар тухайн редакцыг удирдаж байгаа эрхлэгч нарын цаг үеийг мэдрэх мэдрэмж, редакцын нийтлэлийн бодлого, байр суурь, онцлогтой шууд холбоотой. Гэхдээ үүнийг дан ганц редакцын бодлоготой холбон үзэж

болохгүй. Тэгэхээр сэтгүүлчдийн бие даасан байдал, чөлөөт сэтгэлгээ, хүсэл тэмүүлэл энд чухал үүрэгтэй.

Социализмын үеийн сонин хэвлэлд улс орныг тэр чигт нь сэрээсэн, нийгэмд асар өргөн цуурай үүсгэж, нийгмийн том өөрчлөлтөд хүргэсэн нийтлэл ховор гардаг байв. Энэ нь ердөө л сэтгүүлчийн сэтгэн бодох эрх чөлөөтэй холбоотой байсан юм.

**С**этгүүлч бол бүтээлч хүмүүс. Бүтээлч сэтгэхүйтэй хүмүүс юм. Тиймээс тэдний бүтээлч сэтгэхүй, чөлөөт сэтгэлгээг хянаж цагдахгүй, чөлөөтэй тавьж өгснөөр тэдний авьяас билэг ундарч, бүтээлч байдал, ур чадвар дээд зэргээр шавхан гардаг гэдгийг 1985-1990-ээд оны манай нэрт сэтгүүлч, соён гэгээрүүлэгч Лодонгийн Түдэвийн удирдсан “Үнэн” сонины шилдэг нийтлэлийн үер тод харуулсан билээ.

Тэр үед манай нэртэй нийтлэлчид болох Ц.Балдорж, Х.Цэвлээ, Ц.Дашдондов, Ш.Цэен-Ойдов, Ж.Барамсай, О.Дашбалбар нар өөрсдийн алдарт бүтээлүүдээ туурвиж, нийгмийг сэтгэлийн их хөөр баясал, үзэл бодол, сэтгэхүйн асар их өөрчлөлтөд хүргэсэн билээ. Энэ бүгд ердөө л сэтгүүлчийн сэтгэн бодох, бүтээж туурвих эрх, эрх чөлөөг чөлөөтэй тавьж өгсөнтэй холбоотой байсан билээ. Тэгэхээр сэтгүүлчийн бие даасан, хараат бус байдал нь сэтгүүлчийн сэтгэн бодох, бичих туурвих авьяас билиг, ур чадварыг шавхан гаргах том нөхцөл боломж юм гэдэг нь эндээс харагдаж байна.

Чөлөөт сэтгүүл зүй үүссэнээр сэтгүүлчид урьд өмнө бичиж байгаагүй олон төрөл зүйлээр хүчээ сорих боломж нээгдсэн байдаг. Тухайлбал, шинжлэлт буюу аналитик төрөл зүйл,



эрэн сурвалжлах сэтгүүл зүй гэх мэт өмнөх нийгмийн үед тэр бүр бичээд байдаггүй төрлүүдээр бичих туурвих боломж бүрдсэн. Эдгээр төрөл зүйл нь сэтгүүлчээс илүү их ур чадвар, туршлага шаарддаг. Сэтгүүлчийн ямар нэг хайрцаг, үзэл суртал зэрэгт баригдахгүй чөлөөтэй туурвин бүтээх эрх нь сэтгүүлч задгай өргөн хэмжээнд сэтгэн бодох, хэн нэгэн эрхтэн дархтнаас айж эмээлгүй үгээ хэлэх, туурвих, өөрийгөө цэнэх болгоомжлохоос ангид байж, өөрийн хүч авьяасыг гүйцэт дайчлан гаргах, уран тод найруулан бичих боломж нөхцөлийг олгодог гэсэн дүгнэлтийг хийхэд хүргэж байна.

**Ө**мнөх нийгмийн үеийн сэтгүүл зүйд сурвалжлагч илүү үнэлэлт өгөх, сургаал хайрлах, удирдан чиглүүлсэн, уриа лоозон дэвшүүлэх, саарал магтаал хөврүүлсэн нь их бий. Гэхдээ сэтгүүлчид өөрийн редакцын бодлогод тохируулах, дээрээс өгсөн заавар зөвлөмж, өөрийн сонины эздийн, эрхлэгч нарын байр суурьт тааруулах гэдэг хуучин арга барилаасаа салж, шинэ цаг үеийг мэдэрсэн, хүлээн авагчийн мэдээллийн эрэлт хэрэгцээг нэгд тавьдаг болсон зэрэг ололт байна. Энэ нь мэдээлэл болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа нь бизнес болсон, мэдээлэл нь үзэгч, уншигчийн оюуны хэрэгцээ болж хувирсантай холбоотой юм.

Бичлэгийн нэг хэв загварт баригдсан арга хэлбэр, тухайлбал, социалист уралдааны дүн, тэргүүн туршлага, таван жилийн төлөвлөгөөний биелэлт зэрэг жижүүрийн хэдэн сэдвийн хүрээнд эргэлддэг байсныг халж, нийгмийн бүх салбар хүрээ рүү эрчимтэй нэвтэрч, тусгах асуудлын хүрээ өргөжсөн. Сэтгүүлчид ч өөрсдөө үзэл суртлын фронтын

дайчин байлдагчаас ард түмний нүд чих болон хувирах үндэс тавигдсан зэрэг өөрчлөлт гарчээ. Чөлөөт хэвлэл үүссэнээр сэтгүүлч аль ч асуудалд чөлөөтэй хандах, зохиогч өөрийн санаа бодол, үнэлэлт дүгнэлтийг чөлөөтэй тусгах болсон.

Хэвлэл мэдээлэлд гарсан дээрх өөрчлөлт нь Монгол чөлөөт хэвлэл бүрдсэн, сэтгүүлчийн бие даасан хараат бус байдалтай холбоотой гэдэг нь ойлгомжтой. Нийгмийн тогтолцооны өөрчлөлттэй хамт ирсэн энэхүү хүчин зүйл нь сэтгүүлчдийн ур чадварт онцгой нөлөө үзүүлсэн нь тодорхой байна.

Манай нэртэй сэтгүүлч, доктор /Ph.D/ До.Цэнджав: “Сурвалжлагчдаа бичих эрх чөлөө, чөлөөтэй сэтгэн бодох, нийтлэх эрх чөлөөг олгодоггүй, дан ганц эрхлэгч өөрийнхөө хүсэл зоригийг тулгадаг уян биш, царцанги редакц бол ардчиллын өнөөгийн нөхцөлд оршин тогтноход бэрх. Монгол Улс чөлөөт хэвлэл хөгжсөн улс орны тоонд ордог боловч дотооддоо хагас эрх чөлөөтэй хэвлэлүүд оршсоор байгаа нь нууц биш юм. Редакцын хараат бус байдал л сонинд итгэл, нэр нөлөө, хөгжлийн шинэ төлөвийг авчирна” (До.Цэнджав, 2004) хэмээн сэтгүүлчийн хараат бус байдлын мөн чанарыг дүгнэж хэлсэн байна. Ер нь сэтгүүлч хараат бусаар ажиллахад хэвлэл мэдээллийн менежмент хэчнээн чухал болохыг дээрх дүгнэлт бэлээхнээ харуулж байна. Сонин хэвлэл, радио телевизийн зарим удирдлага сэтгүүлчийн хараат бус байдлын ач холбогдлыг хагас ойлгох, ач холбогдол өгөхгүй, сэтгүүлчдэдээ сэтгэн бодох, бичих, нийтлэх эрх чөлөө олгодоггүй, хаан боогдуулдаг, үүнийгээ редакцын

бодлого гэдэг ганц үгээр хаацайлдаг явдал байсаар байна.

Тэгэхээр сэтгүүлчдийнхээ бүтээлч сэтгэхүйг хааж боохгүй, харин ч чөлөөтэй ажиллах бололцоог нь ханган өгч гэмээнэ сэтгүүлчийн авьяас билэг ундрэн оргилж, бүтээж туурвих хүсэл эрмэлзэл нь хөөрч, үүний үр дүнд улс орон, нийгэм, олон нийтийн сэтгэл зүйд хүчтэй нөлөө үзүүлэх төдийгүй, бичсэн туурвисан сэтгүүлчдээ асар их алдар хүндийг авчирдаг байх юм. Тэгэхээр сэтгүүлчийн бие даасан байдал гэдэг ямар чухал гэдэг нь харагдаж байна. Сэтгүүлчийн хараат бус байдал, чөлөөтэй сэтгэн бодох, туурвих эрх, эрх чөлөө нь сайн нийтлэл, нэвтрүүлэг төрөн гарах гол үндэс болдог байна. Үүний үр дүнд зөвхөн уншигч, үзэгч төдийгүй, тухайн сэтгүүлчийн ажиллаж буй хэвлэл мэдээллийн

байгууллага ч гэсэн үр шимийг нь хүртэх нь ойлгомжтой.

Монголд чөлөөт хэвлэл бүрэлдэн тогтсон нь сэтгүүлчийн бие даан, хараат бусаар ажиллах суурь орчныг буй болгосон эерэг тал юм. Гэвч төрөөс хараат бусаар ажиллах зарчмаас бусад нөхцөл нь сэтгүүлчийн бие даан ажиллахад ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Хэдийгээр сэтгүүлчийн хараат бусаар ажиллах суурь зарчим буюу чөлөөт хэвлэл оршин байгаа ч, сэтгүүлч нь ямар мэдээлэл нийтлэх эсэх шийдвэрээ өөрийн байгууллагын ашиг орло-

го, амжилт гэхээс илүүтэйгээр тухайн мэдээллийн мөн чанар, иргэд, уншигчдад хүрэх үнэ цэнэ, ач холбогдолд үндэслэн шийдэх эрхээ тэр бүр эдэлж чадахгүй байна.

Сэтгүүлчийн өөрийн цензур байсаар байна. Сэтгүүлч янз бүрийн байдлаар өөртөө цензур хаалт тогтоосноос болж нийгмийн эрх ашгийг хохироосон хууль бус зүйлийг ч тойрч гарах, өдөр тутмын аахар шаахар зүйлээр сонины хуудсаа дүүргэдэг болсноор иргэдийн мэдэх эрхэд ихээхэн хохирол учирч байна.

Сэтгүүлчийн хараат бус байдал гэдгийг хязгааргүй эрх хэмээн үздэгээс юуг ч, яаж ч бичиж, нийтэлж болох мэтээр ойлгож, үүнээс улбаалан шан харамж, төлбөр авч нийтлэл бичих, хэн нэгнийг захиалгаар намнах, өс хонзонгийн сэдлээр хэн нэгнийг харлуулах,

мөнгөтэй хүмүүсийг ангуучлах, алдаан дээр нь дөрөөлж шантаажлан мөнгө салгах гээд сэтгүүлчийн ёс зүйд харш үйлдлүүд гарах болжээ. Сэтгүүлчийн гаргадаг иймэрхүү бусармаг үйлдлийг редакцын ёс зүйн дүрмээр зохицуулдаг практикийг нэвтрүүлэх, сэтгүүлчдийн өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэл мэдээллийн зөвлөлийн хүч, нөлөөг нэмэгдүүлэн сэтгүүлчдийнхээ алдаа оноо, ёс зүй, оюуны өмч, хэвлэлийн мэдээллийн чанар, хэм хэмжээг өндөр хэмжээнд хянаж явах шаардлага улам бүр нэмэгдэж байна.



**Хэдийгээр сэтгүүлчийн хараат бусаар ажиллах суурь зарчим буюу чөлөөт хэвлэл оршин байгаа ч, сэтгүүлч нь ямар мэдээлэл нийтлэх эсэх шийдвэрээ өөрийн байгууллагын ашиг орлого, амжилт гэхээс илүүтэйгээр тухайн мэдээллийн мөн чанар, иргэд, уншигчдад хүрэх үнэ цэнэ, ач холбогдолд үндэслэн шийдэх эрхээ тэр бүр эдэлж чадахгүй байна**



Сэтгүүлчийн хардах эрхийг эрүүгийн хуулиар шүүдэг, гүтгэлгийг гэмт хэрэг гэж үздэг хуулийн заалт сэтгүүлчийн өөрийн цензурт ташуур болсоор байна. Тэрчлэн сэтгүүлчийн нууц эх сурвалжаа хамгаалах, илчлэхээс татгалзах, мэдээлэл өгсөн этгээд нэрээ нууцлах, төрийн албан хаагчид төр болоод байгууллага, хувь хүний нууцаас бусад өөрийн эрхэлж буй албанд хамаарах мэдээллийг заавал өгөх, мэдээллийг олж авах, эрэн сурвалжлах үеийн хууль эрх зүйн хамгаалалтгүй байгаа нь сэтгүүлчийн хараат бус байдалд муугаар нөлөөлж байна.

#### **Эшлэл**

1. А.Оюунгэрэл. (2009). Олон түмний харилцааны онол . Улаанбаатар.
2. А.Оюунгэрэл. (2009). Олон түмний харилцааны онол . Улаанбаатар.
3. Батсуурь, М. (2010). Редакцын хараат бус байдал:Эрх зүйн зохицуулалт ба харьцуулсан судалгаа. Улаанбаатар: Глоб интернэшнл ТББ.
4. До.Цэнджав. (2004). Хэвлэл мэдээллийн менежмент . Улаанбаатар.

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Зулькафиль. М., Чойсамба. Ч. Сэтгүүлчийн ёс зүй. УБ., 2004.
2. Зулькафиль М. Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ., 2010.
3. Оюунгэрэл А. Олон түмний харилцааны онол. УБ., 2009.
4. Цэнджав До. Хэвлэл мэдээллийн менежмент. УБ., 2004.
5. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль.

#### **Summary**

In this paper, author examined the circumstances of independent journalism in Mongolia as well as the issues preventing journalists from engaging in their profession without restriction. Author also looked at the detrimental effects of overstepping one's professional rights. The writers stress that journalists' creativity is greatly enhanced by professional freedom.

**Key words:** press censorship, professional ethics, journalist independence and role, professional norms.